



**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2021 оны 05 сарын 23 өдөр

Дугаар A/33

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчим хүчний яамны 2021 оны Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, 2021 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж, хариуцсан газар, хэлтэстээ зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг яамны нийт газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Авлигатай тэмцэх газарт хүргүүлж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Р.Батрагчаа/-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

B. Nansantogtokh

Б.НАСАНТОГТОХ



170600197

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2021 ОНЫ АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын
2021 оны 08 дугаар сарын 2-ний өдрийн
А/28... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



№	Үйл ажиллагаа	Арга хэмжээ	Хариуцах газар, албан тушаалтан
Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ алба хаагчийн сонгон шалгаруулалт болон томилоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх.			
1.	1. Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх.	1.1. Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт, нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг" (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох. 1.2. Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод, нээлттэй болгох.	ТЗУГ Ахлах шинжээч Д.Чимидлхам
2.	2. Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох, дэвшүүлэх.	2.1. Албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх тогтолцоог бүрдүүлэх.	ТЗУГ Ахлах шинжээч Д.Чимидлхам

4.	3.Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	3.1.Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг шинэ арга хэлбэрт шилжүүлэх, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх.	ТЗУГ Хуулийн хэлтэс
5.	4.Төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлж, мэдээлэл солилцох нөхцөл, боломжийг сайжруулах.	4.1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох.	ТЗУГ шинжээч Б.Түмэнжаргал
6.		4.2. Мэдээлэл солилцох нэгдсэн сүлжээ, сан байгуулах.	шинжээч Б.Түмэнжаргал
7.	5. Нийтийн албаны сургалтын институт байгуулах, албан тушаалтныг давтан сургах боломжийг бүрдүүлэх.	5.1. Төрийн албаны бүх чиглэлээр богино хугацааны болон давтан сургалт явуулах нийтийн албаны сургалтын институт байгуулах.	ТЗУГ Ахлах шинжээч Д.Чимидлхам
8.		5.2. Сургалтын модуль, давтан сургалтын хөтөлбөр боловсруулах.	ТЗУГ Ахлах шинжээч Д.Чимидлхам
9.		5.3. Авлигын эсрэг сургалт, давтан сургалтыг зохион байгуулах.	ТЗУГ Хуулийн хэлтэс
10.		5.4. Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын албан хаагчдыг сургах.	ТЗУГ Хуулийн хэлтэс
Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх.			

11.	6.Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	6.1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэхэд учрах хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замыг судалж, цахим хэлбэрт шилжүүлэх төрийн үйлчилгээний жагсаалтыг шинэчлэн батлуулах.	ТЗУГ шинжээч Б.Түмэнжаргал
12.		6.2. Төрийн үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх.	ТЗУГ шинжээч Б.Түмэнжаргал
13.	7. Зөвшөөрөл олгох журмыг хялбарчилж, түүнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх..	7.1. Зарим төрлийн зөвшөөрөл олгох, хяналт тавих чиг үүргийг төрийн бус байгууллагад шилжүүлэх	Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
14.	8. Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, чиглэлийг цөөрүүлэх замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох.	8.1. Хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах, хяналт шалгалтын чиглэлийг цөөрүүлэх	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар
15.	9. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах.	9.1. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийлгүүлэх.	ТЗУГ Хуулийн хэлтэс
16.		9.2. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлэх.	

	Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх		
17.	10. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох.	10.1. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд "ЗГ-ын тусгай сангийн мэдээлэл" гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтэс
18.		10.2. Тусгай сангийн хөрөнгийг захиран зарцуулах шийдвэрийн ил тод, нээлттэй байдлыг хангах, иргэд олон нийтийн зүгээс хяналт тавих боломжийг нээх.	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын Санхүүгийн хэлтэс
19.		11.1. Орон нутгийн төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг өрнүүлэх, төсвийн төсөлд олон нийтийн саналыг авч тусгах.	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
20.	11. Төсвийн төсөл хэлэлцэхэд олон нийтийн оролцоог хангах.	11.2. Орон нутгийн төсвийн төсөлд санал авах хэлэлцүүлгийн талаар Засгийн газрын www.iitod.mn , www.shlendans.com цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх.	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
21.	12. Аудитын дүгнэлтийн дагуу авах арга хэмжээ, хариуцлагын тогтолцоог сайжруулах.	12.1. Иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг барагдуулсны улмаас захиргааны байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх тогтолцоог бүрдүүлэх.	ТЗУГ Хуулийн хэлтэс
Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх			

22.	13.Картель, шударга бус өрсөлдөөнийг хязгаарласан эрх зүйн орчинг сайжруулах.	13.1.Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих			
23.	14.Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бий болгох, төрийн зарим ажил үйлчилгээг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, санхүүжилтийг ил тод, гүйцэтгүүлэх, зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	14.1. Төрийн байгууллага, түүний удирдлагын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага хяналт тавих боломжийг бүрдүүлэх. 14.2. Төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсвөөс олгож байгаа санхүүжилтийн зарцуулалтыг ил тод, нээлттэй болгож нийтэд мэдээлэх.	Бодлого, төлөвлөлтийн газар, Төрийн захиргааны удирдлагын газар Бодлого, төлөвлөлтийн газар Санхүү, хөрөнгө оруулалтын газар
24.	Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх		
25.	15. Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэхэд иргэн, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог хангах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	15.1.Төрийн байгууллагуудын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн үр дүнг сайжруулах.	ТЗУГ Хуулийн хэлтэс
26.	16.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх.	16.1.Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа явуулах сургагч багшийг бэлтгэх, чадавхжуулах, мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх.	ТЗУГ Хуулийн хэлтэс

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМНЫ 2021 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын
2021 оны 03 дугаар сарын 28-ний өдрийн
А/38 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хариуцах газар, албан тушаалтан
Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх			
1.	1.1.АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг тухайн орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фэйсбүүк, твиттер, youtube сувар), мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэсэн байх.	Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх	ТЗУГ Хуулийн хэлтэс
	1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллага, салбар нэгж, нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах.	Дэмжиж хамтран ажилласан байх, Салбар нэгж, орон нутаг, зохион байгуулж, үр дүнг тайлагнасан байх.	ТЗУГ Хуулийн хэлтэс
	1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах.	Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх, Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн мэдээллийг байршуулсан байх	ТЗУГ Хуулийн хэлтэс
Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, албан хаагчдыг нараа АТГ-аас зохион байгуулах сургалтад хамруулах			
2.	2.1.Авлигын эсрэг сургалтын санал, захиалгыг төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-ын УССГХ-т хүргүүлэх.	Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх	ТЗУГ Хуулийн хэлтэс

2.2. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах		Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	ТЗУГ Хуулийн хэлтэс
2.3. Авлигын эсрэг сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг өөрсдийн нөөц бололцоо, сургагч багшаар дамжуулан зохион байгуулах		Сургалт, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байх, Хамрагдсан албан хаагчдын тоо	ТЗУГ Хуулийн хэлтэс
Авлигатай тэмцэх газраас бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх			
3.	3.1. Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	ТЗУГ Хуулийн хэлтэс
	3.2. Мөрдөгчийн мэдэгдэл		ТЗУГ Хуулийн хэлтэс
	3.3. Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ		ТЗУГ Хуулийн хэлтэс
Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх			
4.	4.1. Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдсэн байдал;	Хууль тогтоомжид нийцсэн байх	ТЗУГ Хуулийн хэлтэс
	4.2. Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;		ТЗУГ Хуулийн хэлтэс
Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах			
5.	5.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх/	Шинэ шийдэл, технологи нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах	ТЗУГ Хуулийн хэлтэс

Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх /	зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх	
Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах		
6. 6.1. Төсвийн орлого, түүний зарцуулалт, гадаадын зээл, тусламж, түүний хуваарилалтыг олон нийтэд тухай бүр нь мэдээлэх;	Хуулийн хэрэгжилтийг хангуулж, иргэдэд ойлгомжтой хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарсан байх	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
		Санхүү, хөрөнгө оруулалтын газар
6.2. Шилэн дансны мэдээллийг тогтмол байршуулах		
6.3. Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;		

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЯАМ